



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 1102

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 209 дүгээр
цэцэрлэгийн хөрөнгийг данснаас
дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан 1,535,263.0 /нэг сая таван зуун гучин таван мянга хоёр зуун жаран гурван/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Хан-Уул дүүргийн 209 дүгээр цэцэрлэг /Ц.Алтантуул/-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 209 дүгээр цэцэрлэг /Ц.Алтантуул/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115030000263

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2020 оны 03 дугаар
 сарын 24 өдрийн 1102 тоот тушаалын хавсралт



Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 209 дүгээр цэцэрлэг

Д/д	Эд хөрөнгийн нэр	марк дугаар	Үйлдвэрлэсэн он	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр	
											Шилжүүлэх данс	Бүртгэх данс
1	Зурагт /32 инч/	daewoo	2015	4	Ш	1	320,000.00	320,000.00	129,534.30	120,828.70	тавилга эд хогшил	машин тоног төхөөрөмж
2	DVD тоглуулагч		2015	4	Ш	1	60,000.00	60,000.00	175,000.00	-		
3	DVD тоглуулагч	hp	2015	4	Ш	1	160,000.00	160,000.00	170,000.00	-		
4	Зурагт /32 инч/	sony	2015	4	Ш	1	399,900.00	399,900.00	399,899.89	0.11		
5	Тоос сорогч	sony	2015	4	Ш	1	170,000.00	170,000.00	159,999.98	0.02		
6	Будаа агшаагч	sony	2014	5	Ш	1	250,363.00	250,363.00	60,000.00	-		
7	Кварц	sony	2015	4	Ш	1	175,000.00	175,000.00	320,000.00	-		
Нийт үнэ						7		1,535,263.00	1,414,434.17	120,828.83		